

“ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН БАРОМЕТРИЙН СУДАЛГАА ”

ТЕХНИКИЙН САНАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

1. Ерөнхий мэдээлэл “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”-ны мэдээлэл цуглуулах, мэдээллийн бааз үүсгэх ажлыг захиалагчийн мэргэжил, арга зүйн удирдлага, хяналт дор гүйцэтгэх

2. Зөвлөхийг сонгох ажиллагаа Зөвлөх үйлчилгээний зарлалыг 2019 оны 05 дугаар сарын 03-нд “Өнөөдөр сонин”-д нийтлүүлсэн ба 2 байгууллага санал ирүүлсэн бөгөөд үнэлгээний хорооны шийдвэрээр 1 байгууллагыг нэмж 3 байгууллагыг хураангуй жагсаалтанд оруулан тендерийн урилга хүргүүлсэн. Урилга хүргүүлсэн байгууллагуудаас 1 байгууллага тендер ирүүлсэн.

3. Техникийн саналын үнэлгээ “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”-ны зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтанд “SICA” ХХК товлосон хугацаанд тендерээ ирүүлсэн бөгөөд “IRIM” ХХК болон “Амжилтын эзэд” ХХК материалаа ирүүлээгүй болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгаа институтийн захирлын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/07 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо гишүүдийн бүрэн ирцтэйгээр техникийн саналд үнэлгээ хийж гүйцэтгэв. Үнэлгээнд “Зөвлөх үйлчилгээний тендерийн үнэлгээний заавар”, “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг тус тус мөрдлөг болгон ажиллалаа.

ЗҮТББ-д заасан үнэлгээний дэд үзүүлэлт болон холбогдох онооны талаарх үндэслэл:

- (а) Зөвлөхийн ажлын даалгаварт заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэж байсан тусгайлсан туршлага
- (б) Зөвлөхийн санал болгож буй ажлын хөтөлбөр болон аргачлал нь ажлын даалгаварын шаардлагад нийцсэн байдал
- (в) Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэх ахлах судлаач, судлаачдын чадвар болон туршлага

ТББ-ийн ТӨХ-ийн 1.1-д зааснаар Чанарын үнэлгээний аргаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 38.3 зүйлд зааснаар техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан зөвлөхийн санхүүгийн саналыг нээж, тухайн зөвлөхтэй санхүүгийн болон бусад нөхцөлийг харилцан тохиролцох хэлэлцээр хийх зарчмаар зохион байгуулж явууллаа..

Үнэлгээний хорооны үнэлгээгээр техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан “SICA” ХХК-тай санхүүгийн санал болон бусад нөхцлийг тохиролцсоны үндсэнд “Хөдөлмөрийн зах зэлийн эрэлтийн барометрийн судалгаа”-ны мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах эрх олголоо.